

**АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСЛИЙН**

**“Эйч Ай Би” ХХК**

Шифр: 2023/04

**Дорноговь аймаг: Сайншанд сум, 5-р баг.  
Зүүнбаянгийн төвийн 4.0км хатуу хучилттай авто замын  
ажлын зургийн тайлбар бичиг**

Улаанбаатар хот

2023 он

# АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСЛИЙН

“Эйч Ай Би” ХХК

Шифр: 2023/04

Дорноговь аймаг: Сайншанд сум, 5-р баг.  
Зүүнбаянгийн төвийн 4.0км хатуу хучилттай авто замын  
ажлын зургийн тайлбар бичиг

Захирал: ..... Т.Амгаланбаяр

Зургийн инженер ..... Т.Банзрагч



Улаанбаатар хот

2023 он

## 1. Оршил

### 1.1 Үндэслэл

- Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2021-2024/
- Сайншанд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/
- Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замын зураг, төсөв боловсруулах ажлын Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ.

- Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замын зураг, төсөв боловсруулах ажлын даалгавар

- “Зууны хөгжлийн зам” ХХК-ийн хайгуул, байр зүйн зураглалын ажлын тайлан
- Инженер геологийн “Инжгеотех” ХХК-ийн инженер-геологийн судалгааны тайлан

- “Авто зам төсөллөх БНБД 32.01.07”, “Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016”
- “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04.
- Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормал БД31-101-04
- Явган хүний зам талбай төсөллөх техникийн шаардлага MNS6808:2019
- Бусад зураг төсөл зохиох норм ба стандартууд

### 1.2. АЖЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замын ажлын зураг – 1 боть
- Зургийн тайлбар бичиг – 1 дэвтэр
- Зам барилгын ажилд тавигдах техникийн шаардлага – 1 боть
- Инженер геологийн судалгаа, тайлан – 1 дэвтэр
- Ажлын тоо хэмжээ ба хяналтын төсөвт өртөг- 1 дэвтэр

### 1.3. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замын зураг, төсөв боловсруулах.

- Байрлал: Дорноговь аймаг, Сайншанд сумын 5 дугаар багт байрлана.
- Зөвлөх компани: “Эйч Ай Би” ХХК
- Төслийг боловсруулахад оролцсон байгууллагууд:
  - “Инжгеотех” ХХК
  - “Зууны хөгжлийн зам” ХХК

### 1.4. ТӨСЛИЙН ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА

- Дорноговь аймгийн ЗДТГазар

## 1.5. ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1-р зам

д/д	Үзүүлэлт	х/н	Замын техникийн үзүүлэлт
1	Замын ангилал	-	Нутаг дэвсгэрийн гол гудамж зам
2	Замын урт	м	2921
3	Эргэлтийн тоо	ш	5
4	Эргэлтийн муруйн хамгийн бага радиус	м	100
5	Эргэлтийн муруйн хамгийн их радиус	м	15000
6	Эргэлтийн муруйн нийт урт	м	609
7	Муруй хэсгийн трасст эзлэх хувь	%	21
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	18000
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	45000
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	15000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	50000
12	Дагуу налуугийн хамгийн бага утга	%	0.3
13	Дагуу налуугийн хамгийн их утга	%	5.1
14	Дагуу хамгийн их налуутай хэсгийн нийт урт	м	201
15	Замын далангийн өргөн	м	15.0м
16	Зорчих хэсгийн өргөн	м	7.0м
17	Ногоон байгууламжийн өргөн	м	2x2.0м
18	Явган хүний замын өргөн	м	2x1.5м
19	Хөвөөний өргөн	м	2x0.5м
20	Далангийн хажуу налуу	-	1:1.5
21	Ухмлын хажуу налуу	-	1:1.5
22	Хучлагын төрөл	-	Капитал
23	Хучлагын бүтэц	-	Өнгө асфальтбетон - 3см Суурь асфальтбетон - 4см Буталсан чулуун суурь - 20см Хөлдөлтөөс хамгаалах үе - 30см



## 2-р зам

д/д	Үзүүлэлт	х/н	Замын техникийн үзүүлэлт
1	Замын ангилал	-	Нутаг дэвсгэрийн гол гудамж зам
2	Замын урт	м	356
3	Эргэлтийн тоо	ш	-
4	Эргэлтийн муруйн хамгийн бага радиус	м	-
5	Эргэлтийн муруйн хамгийн их радиус	м	-
6	Эргэлтийн муруйн нийт урт	м	-
7	Муруй хэсгийн трасст эзлэх хувь	%	-
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	-
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	-
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	21000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	21000
12	Дагуу налуугийн хамгийн бага утга	%	0.1
13	Дагуу налуугийн хамгийн их утга	%	2
14	Дагуу хамгийн их налуутай хэсгийн нийт урт	м	186
15	Замын далангийн өргөн	м	15.0м
16	Зорчих хэсгийн өргөн	м	7.0м
17	Ногоон байгууламжийн өргөн	м	2x2.0м
18	Явган хүний замын өргөн	м	2x1.5м
19	Хөвөөний өргөн	м	2x0.5м
20	Далангийн хажуу налуу	-	1:1.5
21	Ухмлын хажуу налуу	-	1:1.5
22	Хучлагын төрөл	-	Капитал
23	Хучлагын бүтэц	-	Өнгө асфальтбетон - 3см Суурь асфальтбетон - 4см Буталсан чулуун суурь - 20см Хөлдөлтөөс хамгаалах үе - 30см



3-р зам


д/д	Үзүүлэлт	х/н	Замын техникийн үзүүлэлт
1	Замын ангилал	-	Нутаг дэвсгэрийн гол гудамж зам
2	Замын урт	м	737
3	Эргэлтийн тоо	ш	2
4	Эргэлтийн муруйн хамгийн бага радиус	м	150
5	Эргэлтийн муруйн хамгийн их радиус	м	200
6	Эргэлтийн муруйн нийт урт	м	59
7	Муруй хэсгийн трасст эзлэх хувь	%	17
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	10000
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	10000
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	10000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	10000
12	Дагуу налуугийн хамгийн бага утга	%	3
13	Дагуу налуугийн хамгийн их утга	%	8
14	Дагуу хамгийн их налуутай хэсгийн нийт урт	м	65
15	Замын далангийн өргөн	м	15.0м
16	Зорчих хэсгийн өргөн	м	7.0м
17	Ногоон байгууламжийн өргөн	м	2x2.0м
18	Явган хүний замын өргөн	м	2x1.5м
19	Хөвөөний өргөн	м	2x0.5м
20	Далангийн хажуу налуу	-	1:1.5
21	Ухмлын хажуу налуу	-	1:1.5
22	Хучлагын төрөл	-	Капитал
23	Хучлагын бүтэц	-	Өнгө асфальтбетон - 3см Суурь асфальтбетон - 4см Буталсан чулуун суурь - 20см Хөлдөлтөөс хамгаалах үе - 30см



## 2. ЗАМЫН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

## II.1. Байршил

Дорноговь аймаг. Сайншанд сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр, Зүүнбаян тосгоны төвийн хэсэгчилсэн хатуу хучилттай авто зам шинээр барихаар төлөвлөжээ. (Цооногийн байршлын схем зураг үзнэ үү).



Зураг II.1. Байршлын зураг

## II.2. Уур амьсгал

Авто замын зурвас талбайн уур амьсгалын үзүүлэлтүүдийг "Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт" (БНБД 23-01-09)-ийн Дорноговь аймаг. "Сайншанд" станцын үзүүлэлтээр өгч хүснэгтээр үзүүлээ.

Гаднах агаарын сар, жилийн дундаж температур, °C

Хүснэгт II-1

Станц	Сар												Жил
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Сайншанд	17.9	13.5	-4.2	6.1	14.2	20.4	23.2	21.1	14.0	4.5	-7.4	16.0	3.7

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн их температур, °C

Хүснэгт II-2

Станц	Үнэмлэхүй хамгийн их	Он сар өдөр	VII сарын үнэмлэхүй ихийн дундаж
Сайншанд	42.0	1999.VII.26	35.5

## Агаарын чийгшил, хур тунадасны хэмжээ

Хүснэгт II-8

Станц	Хур тунадас							
	Халуун сар	Хүйтэн сар	Жил	Дулаан үе	Хоногийн хамгийн их	Он	Сар	Өдөр
Сайншанд	41	66	113.5	106.9	121.0	1976	VII	11

## Жил, сарын дундаж салхины хурд

Хүснэгт II-9

Станц	Сар, өвлийн улирал, жилийн дундаж хурд, м/с													
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Өвөл	Жил
Сайншанд	3.7	4.0	4.8	5.7	5.5	4.8	4.0	3.7	3.9	3.8	4.0	3.9	3.9	4.3

## Аянгын дуу цахилгааны муж

Хүснэгт II-10

Муж	Аянга дуу цахилгаантай			1 аянга	1 км <sup>2</sup> талбайд ниргэх тоо
	Өдөр	Дундаж үргэлжлэх, цаг	Хамгийн удаан, цаг	минут	
II	22-36/29/	43-50/46/	56-100	83-121/94/	5-6

## Хурдас (нойтон цас, цан, мөстлөг) субилмацийн үзэгдлийн давтагдал, ачааллын муж

Хүснэгт II-11

Муж	Нойтон цастай		Цантай		Мөстлөгийн			
	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	Зузаан, /ачаалал/ мм	
							10 жилд	5 жилд
IV	1	1-2	1	8-10	1-2	1-3	5	<5

Судалгааны район Монгол орны газрын гадарга дээрх цасны ачааллын III мужид хамаарах ба цасан бүрхүүлийн нормчилсон ачаалал 30 кг/м<sup>2</sup> байна. Судалгааны талбайд тархсан хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүнийг БНБД 23-01-09-ийн хүснэгт 23-аар өгвөл:

- Жижиг ширхэгтэй элсэн хөрс - 2.61 м
- Элсэнцэр хөрс - 2.61 м

б. Судалгааны районы Авто замын бүсүүдийн уур амьсгалын, геотехникийн үзүүлэлтүүдийг "Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн үзүүлэлтээр өгч хүснэгтээр үзүүлээ.



## 1 дүгээр хүснэгт. Бүсийн тодорхойлолт

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл
III. Авто замын уур амьсгалын говь цөлийн бүс	III А.Говийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын нэн хуурай дулаан, хүйтэн хүйтэвтэр хахирлаг говийн цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд бүс.	-Олон жилийн цэвдэггүй, Гео уур амьсгалын улирлын хөлдөлтийн гүн харьцангуй их, 2.2-3.2 м. Хөөлттэй болон суултай хурдас элбэг тархсан.

## 2 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа

Бүс	Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
		Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
III	III А	2-15.XI 9.XI	0-24.III 16.III	126-146 136	25.IY-25.V 1.V	35-55 45	25.IX-1.X 28.IX	145-159 152	42-46 44

## 3 дугаар хүснэгт. Хөрс агаарын температурын (°C) үзүүлэлт

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаарын орчны дундаж температур, °C		
		Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0°нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
III	III А	+3...+7	65-70	-39...-42	200-300	+2...+6	-15...-20	20...25

## 4 дүгээр хүснэгт. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Бүс	Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
		Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
III	III А	1-10.XI 5.XI	25.II-15.III 5.III	110-120 115	20.II-15.III 2.III	1-15.IV 7.IV	10-20 35

## 4б дүгээр хүснэгт. Монгол орны авто замын бүсүүдийн

## хөрсний хөлдөлтийн норматив гүн

Бүс	Дэд бүс	Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м			
		Шавар, шавранцар	Элсэнцэр, тоосорхог элс	Дунд зэргийн элс, хайргархаг элс	Том хэмхэдэст хөрс
III	III А	2.2	2.7	2.9	3.2

## 5 дугаар хүснэгт. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй үеүүд

Бүс	Дэд бүс	Дулааны улирал			Хүйтний улирал
		Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
III	III А	20.III	25.X	219	146

6 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Бүс	Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
		Өвөл	Хавар	Зун	Намар		
III	III А	2.5-4.0	3-6	2-5	2.5-4.5	650-700	40-60

7 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүд дахь хур тунадасны хэмжээ, мм

Бүс	Дэд бүс	Хур тунадасны нийлбэр, мм							
		Өвөл	Хавар	Зун	Намар	Жил	1 хоногт орох борооны хамгамж, мм		Борооны хамгийн их орох эрчим мм/мин
							2%	1%	
III	III А	3-5	10-20	80-140	20-25	75-200	70	90	0.25-0.50

8 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсийн нарны цацраг, нарны гийгүүлэлийн хэмжээ

Бүс	Дэд бүс	Нарны цацраг, Мд/м <sup>2</sup>			Нарны гийгүүлэл, цаг				
		Нийлбэр	Шууд	Шингэсэн	Жил	XII	VI	XII сарын 1 өдөрт	VI сарын 1 өдөрт
III	III А	4700-5300	2800-3400	3800-4300	3100-3200	180-200	300-310	7-8	9-10

9 дүгээр хүснэгт. Авто замын техник ашиглалтын түвшинд сөргөөр нөлөөлж болох уур амьсгалын үзэгдлүүд, мөчлөгийн хэмжээ

Бүс	Дэд бүс	Техникийн уур амьсгалын хахир хатуу, балл		Уур амьсгалын хахиршил, балл	Нийт аянгын үйлчлэл		1 аянгын	
		Хүйтний	Дулааны		Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Үргэлжлэх минут	1 км <sup>2</sup> талбайн ниргэлтийн тоо
III	III А	40-60	20-25	3-4	10-20	15-35	55-80	3-5

9 дүгээр хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
		Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Зузаан, мм 10 жилд	Зузаан, мм 5 жилд
III	III А	1-3	2-3	2-3	8-10	1-2	10	5



## 9 дүгээр хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Ачаалал, кг/м <sup>2</sup>		Металлын зэврэлт болох хугацаа, цаг	Тохиромжгүй өдрийн тоо					
		Салхины	Цасны		Халуун	Цасан шуургатай	Шороон шуургатай	Хүчтэй салхитай	Бороотой	Цастай
III	III А	55-65	30-40	1000-1500	35-45	3-5	30-40	15-20	25-40	15-25

## 9 дүгээр хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Халууны нөөц нийлбэр, °С		Хүйтний нөөц нийлбэр, °С			Хүйтний үргэлжлэх хугацаа, цаг		
		+20	+25	-20	-25	-30	-20°С	-30°С	-40°С
III	III А	1100-1500	500-1200	1000-1400	<500	<100	800-1300	100-200	<1

## 9 дүгээр хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой цасан бүрхүүл					
		Тогтох	Ханзрах	Хоног	Хамгийн зузаан дундаж, см	Нягт, г/см <sup>3</sup>	Нөөц, ус
III	III А	1-10.III	20.II-10.III	40-60	5-10	0.15-0.20	5-10

## 9 дүгээр хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой хүйтэн үед цочир дулааралттай, замд хальтиргаа гулгаатай байх хугацаа		Хүйтэн улирлын жавар хавсрагатай (>8 м/с), хахир үе		Хөрсний 0-50 см гүний чийгшлийн нөөц, мм	
		Эхлэх	Дуусах	Өдрийн тоо	Цаг	Хавар	Намар
III	III А	1.III	25.II	125-130	650-900	5-10	10-30

## 10 дугаар хүснэгт. Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Бүс	Дэд бүс	Гол мөрний гадаргын ус							
		Нягтшил	Жилийн дундаж урсац, л/сек	Дундаж урсацын давхраа, мм	Хаврын шар усны үерийн хамгийн их урсац, мм	Модуль, л/сек, ам.км	Мөсний хамгийн их зузааны дундаж, см	Мөс хадгалах хугацаа	Мөс задрах хугацаа
III	III А	0.01-0.04	0.01-1	<25	<10	0.2-0.4	*	*	*

11 дүгээр хүснэгт. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Бүс	Дэд бүс	Хүчил төрөгчийн нягт, г/см <sup>3</sup>	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлын нөхцлөөр тооцов).			Уур амьсгал хүний биед, хоног		
			Өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
III	III А	250-255	4-4.5	2.5-3.0	1-1.3	180-195	120-135	20-30

12 дугаар хүснэгт. Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
		Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
III	III А	0.90	1.07	1.14	0.64	0.95

12 дугаар хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр			
		Хүчтэй салхи шуурганы	Аянга цахилгааны	1 удаагийн их борооны	Цасны
III	III А	1.15	0.69	0.65	0.55

12 дугаар хүснэгтийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр						Уур амьсгалын үндсэн итгэлцүүр
		Хөдөлмөр хамгаалалын хувцасны нөлөөлөл			Хүний биед уур амьсгалын нөлөөлөл			
		Өвөл	Хавар, намар	Зун	Таатай	Цочроох	Хурц	
III	III А	0.83	0.95	0.72	1.03	1.10	0.80	0.92

14 дүгээр хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Бүс	Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
		Эхлэх	Дуусгах	Хоног
III	III А	9.IV-2.V (20.IV)	5.IX-2.X (18.IX)	129-176 (151)



15 дугаар хүснэгт. Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальтон бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Бүс	Дэд бүс	Асфальтон болон замын хучилт		
		Эхлэх	Дуусгах	Хоног
III	III А	23.II-15.III (5.III)	12.XI-11.XII (27.XI)	244-301 (267)

16 дугаар хүснэгт. Авто замын шороон далангийн хөрсний чийг-дулааны горимын мөчлөгүүд

Бүс	Дэд бүс	Замын даланд намар чийг хуримтлагдах			Даланд өвлийн чийг хуримтлагдах		Замын ул хөрс гэсэж чийгээр ханах		Замын далан хуурайших
		Эхлэх	Дуусах	Хоног	Дуусах	Хоног	Дуусах	Хоног	Хоног
III	III А	20.X	20.XI	31	24.III	124	1.V	38	172

17 дугаар хүснэгт. Ухмал буюу далангүйгээр баригдах замын хучилтын гадаргууг гүний усны төвшингөөс дээш өргөх болон ул хөрсийг солих зузааны хамгийн бага хэмжээ

Ажлын үеийн хөрс	Хучилтын гадаргууны төвшинг өргөх доод хэмжээ, м (Авто замын бүсүүдэд)
	III А
Нарийн ширхэглэлтэй элс, том ширхэглэлтэй хөнгөн элсэнцэр, хөнгөн элсэнцэр	0.5
Тоосорхог элс, тоосорхог элсэнцэр	0.8
Хүнд тоосорхог элсэнцэр, хөнгөн тоосорхог шавранцар, хүнд тоосорхог шавранцар	1.1
	0.2
Хөнгөн ба хүнд шавранцар, шавар	1.2
	0.3

18 дугаар хүснэгт. Цасан хунгарт автагдахгүй байх нөхцлийн үүднээс замын далангийн өндрийн сонголт

Бүс	Дэд бүс	Далангийн байж болох хамгийн бага өндрийг тооцох, /м/ Авто замын техникийн зэрэглэл бүрээр				
		I	II	III	IV	V
III	III А	$\frac{0.5 - 0.10}{0.84}$	$\frac{0.5 - 0.10}{0.35}$	$\frac{0.05 - 0.10}{0.28}$	$\frac{0.05 - 0.10}{0.24}$	$\frac{0.05 - 0.10}{0.18}$

### II.3. Геологийн тогтоц

Авто замын зурвас талбай орчимд геологи, гарал үүслийн 2 төрлийн хурдас, чулуулаг хуримтлагдаж тогтсон. Үүнд:

а. Гуравдагч-дөрөвдөгчийн хурдас

Нуур-пролювийн гаралтай хурдас тархсан. Сэвсгэр хурдаснаас зонхилон янз бүрийн ширхэгтэй элс, элсэнцэр болон элсэн чигжээстэй сайр, сайрга, элсэнцэр чигжээстэй сайр, сайрга, шавранцар, шавар хөрс тархсан.

#### б. Элсэн чулуу, занарын зузаалаг

Дээд цэрд, палеогены настай цайвар саарал өнгөтэй, элсэн чулуу түүний хүчтэй өгөршил зонхилон тархсан байна.

Авто замын зурвас талбайд геологи, гарал үүслийн ангиллаар Сайншандын свит ( $K_2^{BS}$ )-ын хурдас чулуулаг конгломерат, сайн мөлгөржсөн сайр, сайрга, палеозойн элсэн чулуу, занар, Батширээтийн свит ( $K_2^{BS}$ )-ын хурдас чулуулгийг улаан хүрэн өнгөтэй шавар, саарал өнгөтэй элсэн чулуу, янз бүрийн ширхэгтэй элс бүрдүүлнэ.

#### II.4. Геоморфологийн хэв шинж

Авто замын зурвас талбай нь газар зүйн ангиллаар Монголын Дорнод талын Их мужийн ухаа гүвээт талын дэд мужид хамаарна. Авто замын зурвас талбай нь ухаа гүвээний Элэгдэл-зөөгдлийн хэв шинжит гадаргууд байрлана. Судалгааны талбай нь хойноосоо урагш хэвгий тогтоцтой. Судалгааны талбайн газрын гадаргуугийн өндөржилт нь 753.576-757.286 м -ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өндрийн зөрүү нь 3.71 м байна.

#### II.5. Гидрогеологийн нөхцөл

Судалгааны район нь гадаргуугийн усан сүлжээний хувьд муу хөгжсөн. Тал хөндийгөөр хужир, марз, цөөрөмтэй боловч эдгээр нь хур бороо багатай сар, улиралд ширгэж үгүй болох бөгөөд бороо, хуртай үед устай болж сэргэнэ. Энэ үйл ажиллагаа байнга давтагдан явагддаг байна. Багийн төвийн айл, өрхүүд албан байгууллага, ард иргэд гүний худгийн усаар ундаалдаг. Судалгааны талбайд өрөмдсөн 3 цооногоос хөрсний ус илрээгүй (2021-10 сарын 23-ны байдлаар).

#### II.6. Физик-геологийн үзэгдэл, үйл явц

Авто замын зурвас талбай нь газрын гадаргуугийн хэвгий тогтоцтой уялдан бороо, хуртай үед гадаргуугийн угаагдал явагдах өндөр нөхцөлтэй.

#### II.7. Хөрсний физик - механик шинж чанар

Авто замын зурвас талбайд өрөмдсөн 3 цооногоос 2 төрлийн хөрсний үе илэрсэн. Судалгааны талбайд илэрсэн асгамал хөрс нь жижиг ширхэгтэй элсэн



хөрс болон элсэнцэр хөрсийг хучиж тогтсон. Жижиг ширхэгтэй элсэн хөрс нь талбайн болоод гүний зузаалаг ихтэй тархсан байна. Хөрсний найрлага бүтцийг харгалзан инженер-геологийн 2 элементэд ангилаж үзлээ (ИГЭ). Судалгааны талбайд илэрсэн асгамал хөрсийг тусгайлан авч үзээгүй болно. Үүнд:

ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элсэн хөрс ( $K_2^{BS}$ )

Бор саарал, бор шаргал өнгөтэй, нуур-пролювийн гаралтай, бага чийгтэй, жижиг ширхэгтэй элсэн хөрс судалгааны талбайд асгамал хөрсний доороос илэрсэн. Жижиг ширхэгтэй элсэн хөрс нь талбайн болоод гүний тархалт ихтэйгээр хуримтлагдаж тогтсон. Жижиг ширхэгтэй элсэн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайр, хайрга	3.5
• Элс	73.1
• Тоос	18.2
• Шавар	5.2 тус тус агуулна.

Жижиг ширхэгтэй элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг, хувь	0.064
• Хувийн жин, $г/см^3$	2.65
• Эзэлхүүн жин, $г/см^3$	1.76
• Цогцсын эзэлхүүн жин, $г/см^3$	1.66
• Сүвшил, %	37.48
• Сүвшлийн итгэлцүүр	0.600
• Чийглэгийн зэрэг	0.28

Жижиг ширхэгтэй элсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 2.02.01-94-ийн Хүснэгт 1-ээр өглөө.

*Норматив утга:*

• Зууралдлын хүч	$C^H = 2$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^H = 30^\circ$
• Хэв гажилтын модуль	$E = 28$ МПа

*Тооцооны утга:*

• Зууралдлын хүч	$C^I = 1.3$ кПа	$C^{II} = 2$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^I = 27^\circ$	$\varphi^{II} = 30^\circ$
• Тооцооны эсэргүүцэл	$R_0 = 350$ кПа	

Жижиг ширхэгтэй элсэн хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл 600-650 Ом.м байна. Жижиг ширхэгтэй элсэн хөрс *Овойлтгүй* хөрсөнд нормчилогдоно. Жижиг ширхэгтэй элсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - I.

ИГЭ - 2. Элсэнцэр хөрс ( $K_2^{BS}$ )

Бор саарал, бор шаргал, цайвар шаргал өнгөтэй, нуур-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, элсэнцэр хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл  $l\%/l$ :

• Хайр, хайрга	2.5
• Элс	81.7
• Тоос	9.5
• Шавар	6.3 тус тус агуулна.

Элсэнцэр хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл:

• Байгалийн чийг, хувь	0.087
• Урсалтын хязгаар дахь чийг, хувь	0.174
• Имрэгдлийн хязгаар дахь чийг, хувь	0.126
• Уян налархайн тоо, хувь	0.048
• Хувийн жин, $г/см^3$	2.68
• Эзэлхүүн жин, $г/см^3$	1.77
• Цогцсын эзэлхүүн жин, $г/см^3$	1.63
• Сүвшил, %	39.32
• Сүвшлийн итгэлцүүр	0.652
• Чийглэгийн зэрэг	0.35
• Консистенц	<0

Элсэнцэр хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив утгыг БНБД 2.02.01-94-ийн 2, 3 дугаар хүснэгтээр өглөө:

*Норматив утга:*

• Зууралдлын хүч	$C^H = 15$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^H = 26^\circ$
• Хэв гажилтын модуль	$E = 16$ МПа

*Тооцооны утга:*

• Зууралдлын хүч	$C^I = 10$ кПа	$C^{II} = 15$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^I = 23^\circ$	$\varphi^{II} = 26^\circ$
• Тооцооны эсэргүүцэл	$R_0 = 300$ кПа	

Элсэнцэр хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл 250-270 Ом.м байна. Элсэнцэр хөрс нь *Сулавтар хүчтэй овойлттой* хөрсөнд нормчилогдоно. Элсэнцэр хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад - II.



## II.8. Цооногийн бичиглэл

## Цооног 1

Гүн: 4.5 м	Өндөржилт: 757.220 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.50)/0.50
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.50-2.00)/1.50
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.00-3.80)/1.80
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.80-4.50)/0.70

Газрын доорх ус илрээгүй.

## Цооног 2

Гүн: 4.5 м	Өндөржилт: 757.124 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.80)/1.40
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.80-4.00)/2.20
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(4.00-4.50)/0.50

Газрын доорх ус илрээгүй.

## Цооног 3

Гүн: 7.0 м	Өндөржилт: 756.160 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.50)/1.10
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.50-3.80)/2.30
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.80-7.00)/3.20

Газрын доорх ус илрээгүй.

## Цооног 4

Гүн: 4.5 м	Өндөржилт: 758.089 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.30)/0.90
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.30-4.00)/2.70
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(4.00-4.50)/0.50

Газрын доорх ус илрээгүй.

## Цооног 5

Гүн: 6.0 м	Өндөржилт: 758.596 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(0.40-3.20)/2.80
3. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.20-6.00)/2.80

Газрын доорх ус илрээгүй.

## Цооног 6

Гүн: 4.5 м	Өндөржилт: 759.281 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.00)/1.60
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.00-3.40)/1.40
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.40-4.50)/1.10

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 7

Гүн: 4.5 м	Өндөржилт: 760.463 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.50)/2.10
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.50-3.50)/1.00
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.50-4.50)/1.00

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 8

Гүн: 6.0 м	Өндөржилт: 760.127 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.60)/2.20
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.60-4.00)/1.40
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(4.00-6.00)/2.00

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 9

Гүн: 4.5 м	Өндөржилт: 760.556 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-3.00)/2.60
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(3.00-4.10)/1.10
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(4.10-4.50)/0.40

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 10

Гүн: 4.5 м	Өндөржилт: 762.473 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.50)/2.10
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.50-3.60)/1.10
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.60-4.50)/0.90

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 11

Гүн: 4.5 м	Өндөржилт: 763.629 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.05
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.00)/1.60
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.00-3.00)/1.00
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.00-4.50)/1.50

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 12

Гүн: 4.5 м	Өндөржилт: 763.211 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.05
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-2.00)/1.60
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(2.00-3.10)/1.10



4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр (3.10-4.50)/1.40

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 13

Гүн: 4.5 м	Өндөржилт: 762.553 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.05
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.90)/1.50
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.90-3.00)/1.10
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.00-4.50)/1.50

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 14

Гүн: 4.5 м	Өндөржилт: 762.885 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.05
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.80)/1.40
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.80-2.90)/1.10
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(2.90-4.50)/1.60

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 15

Гүн: 4.5 м	Өндөржилт: 762.856 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.05
1. Үүсгэмэл хөрс	(0.00-1.20)/1.20
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(1.20-1.80)/0.60
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.80-3.00)/1.20
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.00-4.50)/1.50

*Газрын доорх ус илрээгүй.*

Цооног 16

Гүн: 4.5 м	Өндөржилт: 759.281 м
Диаметр: 168; 146	Огноо: 2023.09.04
1. Үүсгэмэл хөрс	(0.00-0.40)/0.40
2. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(0.40-1.80)/1.40
3. Бор шаргал, бор саарал өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элс	(1.80-3.20)/1.40
4. Бор шаргал өнгөтэй, хатуу урсамтгайн үзүүлэлттэй элсэнцэр	(3.20-4.50)/1.30

*Газрын доорх ус илрээгүй.*

### 3. ЗАМЫН ГЕОДЕЗИ, ЗУРАГЛАЛЫН АЖИЛ

Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замыг 1:500-ны масштабтай байр зүйн тоон зураглалын ажлыг “Зууны хөгжлийн зам” ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 04-нээс 09 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд геодезийн инженерээр ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй, суудлын нэг машинтайгаар хийж гүйцэтгэв.

#### Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ
2. Геодезийн тулгуур цэгийн судалгаа			
2.1	Геодезийн хуучин цэгийн судалгаа, сэргээн босголт	цэг	2
2.2	Цэг тэмдэгтийн хувийн хэрэг	цэг	2
3. 1:500-ны масштабтай байр зүйн тоон зураглал			
3.1	Байр зүйн тоон зураглал M1:500	га	24.0
3.2	Суурин боловсруулалт	га	24.0
4.	Тайлан бэлтгэх	хувь	2

Дээрхи ажлуудыг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Геодезийн Газрын зураглалын ажлын норм дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Хэмжилтийн ажилд Хятад улсын “Kolida” фирмийн k5plus+ маркийн GPS хүлээн авагч, Leica фирмийн Sprinter-250M маркийн тоон нивелир ашиглав. Дэвсгэр зураг, геодезийн цэг тэмдэгтийн координат өндрийн өгөгдөлд үндэслэн хэмжилт зураглалын ажлыг UTM-ын координатын системд хийж гүйцэтгэв. Замын нийт уртад электрон тахеометрээр трассын нийт уртад дагуу, хөндлөнгийн зураглал хийсэн.



## 3.1. Хуучин цэгийн судалгаа

Тус объектод хамгийн ойр байгаа GPS-ийн сүлжээний цэгүүдийг судалж, тэдгээрийг уг зам хайгуул судалгааны зураглалын ажын үндэслэл болгон ашиглав.

Эдгээр цэгүүдийн координатыг дараах хүснэгтэнд харуулав:

д/д	Реперийн дугаар	Солбилцол		Z
		X	Y	
1	ПЦ- 0205	425386.130	4929924.240	764.017
2	ПЦ- 2238	426519.510	4932171.320	756.810

## 3.2. Байрлал, өндрийн сүлжээ

A. GPS-ийн хэмжилт

Зураглалын байрлалын өндрийн үндэслэлийг “Kolida” фирмийн 2 долгионы GPS-ийн хүлээн авагч “k5plus+” багажаар хэмжиж тодорхойлосон ба хэмжилтийн өгөгдлүүдийг дараах байдлаар тодорруулан гүйцэтгэсэн болно.

- Хэмжилийн горим UTM
- Хиймэл дагуулыг хүлээн авах өнцөг 15°
- Хамгийн цөөн хиймэл дагуулын тоо 8 буюу их
- Хамгийн их PDOP-ийн утга 3

“Kolida GPS K5plus+”-ын техникийн үзүүлэлт

GPS -ийн хиймэл дагуулаас хүлээн авах долгион 24 суваг, долгион L1, L2

GNSS-ийн хиймэл дагуулаас хүлээн авах долгион 24 суваг, долгион L1, L2

Байршил тодорхойлох нарийвчлал:

Стастик горимд	Байршил	-	5mm+1ppm
	Өндөр	-	10mm+1ppm
Хөдөлгөөнт горимд	Байршил	-	12mm-1ppm
	Өндөр	-	15mm+1ppm
RTK горимд	Байршил	-	12mm-1ppm
	Өндөр	-	15mm+1ppm

Ажиллах температур -30°c

Б. Шинэ цэг суулгалт

Шинээр трассын эхлэл болон төгсгөлд цэг суулгаж тэмдгэлсэн ба цэгүүдийн байрлал өндрийн RTK хэмжилтээр хэмжиж тодорхойлсон болно.

В. Хавтгайн солбицлын тусгаа

Авто замын зураглалыг Монгол улсад мөрдөгдөж байгаа UTM солбицлын системийг тулгуур болгон ашигласан ба тусгагийн өгөгдлүүдийг доор үзүүлэв.

Суурь эллипсоид	UTM
Тусгаг	Transvers Mercater
зоны дугаар	18
Төвийн мериданы утга	105°
У тэнхлэгийн эхлэлийн утга	500000 м
Х тэнхлэгийн эхлэлийн утга	0
Төвийн мериданы дагуух масштабын утга	1.00000

## 3.3. 1:500-ны масштабтай байр зүйн тоон зураглал

А. Хээрийн зураглал

Байр зүйн тоон зураглалыг замын трассын дагуу замын тэнхлэгээс хоёр тийш хамгийн ихдээ 50 м өргөн зурвасаар хэмжиж зурагласан болно. газрын гадаргуй үүсгэх цэгийг гадаргуйгаас хамааран (пикет) хоорондын зайг 5-20 метр тутамд хэмжиж зураглав. Мөн трассын дагуух хэмжилтийн зурваст орж байгаа дараах инженерийн шугам сүлжээ болон байр зүйн элементүүдийг хэмжиж зураглав. үүнд

- ЦДАШ өндөр болон нам хүчдэлийн шугам,
- Холбооны шугам,
- Гүүр хоолой,
- Хашаа хороо,худаг ус,
- Газар доорх далан хоолой болно.

Зураглалын хэмжилтийг “Kolida” фирмийн 2 долгионы GPS хүлээн авагч “K5plus+” багажаар хэмжиж зураглав.

Б. Суурийн боловсруулалт

- GPS боловсруулалтын “Kolida GEO OFFICE”
- GPS боловсруулалтын “KOLIDA GEOMATICS OFFICE”
- 3 хэмжээст гадаргуу үүсгэх “SDR mapping & design”
- Байр зүйн элементүүдийг таних тэмдгээр зурах “TX mapper” ба “AutoCAD 2018”
- Невелирээс өгөгдөл авар “Sprinter Data Loader “

## 4. ЗАМЫН ТРАССЫН ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН СТАНДАРТ

### 4.1 Ерөнхий

Авто зам, хиймэл байгууламжийн зургийг төлөвлөхдөө Монгол улсад мөрдөгдөж буй "Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016", "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНБД30-01-04, "Авто зам төсөллөх" БНБД 32-01-07, "Авто замын гүүр ба хоолой" БНБД32-02-03-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллав.

### 4.2 Замын ангилал, замын зэрэглэл

Төлөвлөж буй Дорноговь аймаг: Сайншанд сум, 5 дугаар баг, Зүүнбаянгийн төвийн хэсэгчилсэн 4.0км авто замын ажлын зураг төсөл боловсруулах техникийн даалгавар, тухайн бүс нутгийн байдлыг тооцож:

Замын ангилал – Нутаг дэвсгэрийн гол гудамж зам

### 4.3 Замын тооцоот өгөгдөл (БНБД30-01-04-ийн хүснэгт-10)

Тооцоот хурд - 60км/цаг

Замын зурвасын өргөн – 3.5м

Зурвасын эгнээний тоо – 2

Явган хүний замын өргөн – 1.5м

Хамгийн их дагуу налуу - 6%

Хөвөөний өргөн – 0.5м

Ногоон зурвас – 2м


### 4.4 Авто замын трасс төлөвлөлт

Авто замын трассыг төлөвлөхдөө ерөнхий төлөвлөгөөний дагуу төв гудамжаар одоо байгаа хуучин замын трассыг дагуулан БНБД-ийг баримтлан төлөвлөсөн.

Трассын хувилбаруудыг гарган Аймийн ЗДТГазарын холбогдох албаны мэргэжилтэн болон инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөж шийдвэрлэсэн.



## Трассын тойм зураг



Тайлбар:

- Төлөвлөж буй авто замын трасс-1
- Төлөвлөж буй авто замын трасс-2
- Төлөвлөж буй авто замын трасс-3



## 1. ПК0+00 – ПК29+21 хүртэлх 2.92км авто зам

Цэгийн нэр	Өнцгийн оройн байрлал			Координат		Эргэлтийн өнцөг		Радиус, м	Азимут	ӨО хоорондын зай, м
	км	пк	+	X	Y	зүүн	баруун			
Замын эхлэл	0	0	0.000	4926946.602	423908.572					
									28°22'51"	500.00
Өн - 1	0	5	0.000	4927386.507	424146.236	1°57'20"		4000		
									26°25'31"	750.68
Өн - 2	1	12	50.672	4928058.757	424480.313		4°06'30"	2000		
									30°32'01"	303.23
Өн - 3	2	15	53.840	4928319.939	424634.366		0°46'24"	15000		
									31°18'25"	569.17
Өн - 4	2	21	23.006	4928806.235	424930.119	34°04'00"		100		
									357°14'24"	426.75
Өн - 5	3	25	47.939	4929232.489	424909.571		19°07'57"	200		
									16°22'21"	373.36
Замын төгсгөл	3	29	20.677	4929590.714	425014.816					

## 2. ПК0+00 – ПК3+56 хүртэлх 0.36км авто зам

Цэгийн нэр	Өнцгийн оройн байрлал			Координат		Эргэлтийн өнцөг		Радиус, м	Азимут	ӨО хоорондын зай, м
	км	пк	+	X	Y	зүүн	баруун			
Замын эхлэл	0	0	0.000	4928263.887	424597.287					
									333°49'09"	355.57
Замын төгсгөл	0	3	55.570	4928582.978	424440.407					

## 3. ПК0+00 – ПК7+37 хүртэлх 0.74км авто зам

Цэгийн нэр	Өнцгийн оройн байрлал			Координат		Эргэлтийн өнцөг		Радиус, м	Азимут	ӨО хоорондын зай, м
	км	пк	+	X	Y	зүүн	баруун			
Замын эхлэл	0	0	0.000	4929497.932	424991.205					
									51°21'15"	486.73
Өн - 1	0	4	86.730	4929801.897	425371.351	33°49'00"		100.00		
									17°32'15"	252.02
Замын төгсгөл	1	7	36.972	4930042.200	425447.292					

## 4.5 Хөндлөн огтлолын параметр

Төлөвлөж буй замын хөндлөн огтлолын техникийн параметруудийг БНБД-30.01.04-ийн шаардлагын дагуу сонгож авсан.

Үүнд:

Зорчих хэсгийн өргөн – 7.0м /хөдөлгөөний зурвасын тоо-2/

Явган хүний зам – 1.5м /2\*1.5м/

Ногоон байгууламж – 2.0м /2\*2.0м/

Хөвөөний өргөн – 0.5м /2\*0.5м/


Далангийн өргөн – 15.0м

Төлөвлөж буй замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий 2% буюу нэг талруугаа налуутай, хөвөөний хөндлөн хэвгий 4% болно.

Далангийн хажуу налуугийн хэмжээг 1:1.5 -р авав.

## Замын нэг маягийн хөндлөн огтлол

Төрөл-1





#### 4.6 Босоо төлөвлөлт

Дагуу огтлолыг төсөллөх үндсэн параметр:

- Налуу
- Муруйн радиус

Төлөвлөж буй автозамын дагуу огтлолын төлөвлөлтийг талбайн геодезийн хэмжилтийн материал дээр үндэслэн Indorcad23 программаар боловсруулсан ба зам барилгын ажлын өртгийг аль болох хямд байлгахыг бодолцож гадаргуун ус зайлуулалтыг тооцож төлөвлөлтийг хийж гүйцэтгэлээ.

Гадаргуун усыг зайлуулах үүднээс дагуу налуугүй төлөвлөхөөс аль болох зайлсхийж төлөвлөж өгөв.

Зорчих хэсэг дээрхи хамгийн их дагуу огтлолын утга 5,1% байх бөгөөд 201м үргэлжилнэ.

Дагуу огтлолын Босоо масштаб 1:100 , Хэвтээ масштаб 1:1000 байна.

Трассуудыг 20м тутамд хувааж төлөвлөлтийн өндөржилтийг дагуу огтлолд үзүүлэв.

Налуу, радиус гэх мэт босоо муруйн деталуудыг дагуу огтлолын зүүрагт үзүүлэв.

Замын 20м тутамд тэмдэглэсэн цэгүүдэд далангийн өндөр болон тэдгээрийн хажуу налуу, газрын гадаргуугийн хэлбэр, гадаргуугийн ус зайлуулалт зэргээс хамааран хөндлөн огтлолыг 20м тутамд төлөвлөж зам барилгын ажлын газар шорооны ажлын тоо хэмжээг гаргасан.

##### 1. ПК0+00 – ПК29+21 хүртэлх 2.92км авто зам

Эхлэл, ПК	Төгсгөл, ПК	Радиус, м	Дундаж налуу, ‰	Налуу эхлэл, ‰	Налуу төгсгөл, ‰	Элементийн урт
0+00.000	1+67.161	—	3			167.16
1+67.161	2+30.469	16000		3	-1	63.31
2+30.469	6+09.680	—	-1			379.21
6+09.680	6+66.656	-12000		-1	4	56.98
6+66.656	10+14.327	—	4			347.67
10+14.327	10+95.525	40000		4	2	81.20

10+95.525	15+80.745	—	2			485.22
15+80.745	16+72.710	-66000		2	3	91.97
16+72.710	25+83.045	—	3			910.33
25+83.045	26+84.543	42000		3	1	101.50
26+84.543	29+20.677	—	1			236.13

2. ПК0+00 – ПК3+56 хүртэлх 0.36км авто зам

Эхлэл, ПК	Төгсгөл, ПК	Радиус, м	Дундаж налуу, ‰	Налуу эхлэл, ‰	Налуу төгсгөл, ‰	Элементийн урт
0+00.000	3+55.570	—	4			355.57

3. ПК0+00 – ПК7+37 хүртэлх 0.74км авто зам

Эхлэл, ПК	Төгсгөл, ПК	Радиус, м	Дундаж налуу, ‰	Налуу эхлэл, ‰	Налуу төгсгөл, ‰	Элементийн урт
0+00.000	1+48.981	—	-7			148.98
1+48.981	2+46.797	-10000.00		-7	3	97.82
2+46.797	5+64.407	—	3			317.61
5+64.407	6+72.151	10000.00		3	-8	107.74
6+72.151	7+36.972	—	-8			64.82

## 5.ХЭСЭГЧИЛСЭН АВТО ЗАМЫН ХУЧИЛТЫН ХИЙЦ ТӨЛӨВЛӨЛТ

Хучилтын хийцийг “Авто замын уян хучилтыг төсөллөх тооцооны аргачлал - 2010 он”, “Монгол орны асфальтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог – 2010 он” ном, "Авто зам төсөллөлт" 2014 он, ВСН 46-83 норм дүрмүүдийг ашигласан.

### Хөдөлгөөний эрчим

Дорноговь аймаг: Сайншанд сумын төвийн хэсэгчилсэн хатуу хучилттай авто замын хучилтын хийцийг төлөвлөхдөө замын ангилал, хөдөлгөөний эрчмээс нь хамааруулан нэг тэнхлэг дээрхи ачааллыг 10тн/1/, ачаалал дамжуулах дугуйн мөрний диаметрийг 33см/2/-ээр тооцлоо. Тухайн замын бодит хөдөлгөөний эрчмийн судалгаан дээр үндэслэн тооцоот хөдөлгөөний эрчмийг тодорхойлж гаргалаа. Өдрийн эрчмийг тооцоолохдоо хөдөлгөөний идэвхитэй 12 цагийн нийт эрчмийг хоногийн эрчим болгон тооцоонд ашигласан. Бодит хөдөлгөөний эрчмийг А группын ачаалалд шилжүүлж доорхи хүснэгтэд үзүүлэв.

2021 оны 8 дугаар сард хийсэн хөдөлгөөний эрчимийн судалгааны дүгнэлтийг үндэслэн тухайн замд өдрийн цагийн дундаж эрчимийг тооцоолохдоо хөдөлгөөний идэвхитэй 12 цагийн нийт эрчмийг хоногийн эрчим болгон тооцоонд ашигласан. Бодит хөдөлгөөний эрчмийг А группын ачаалалд шилжүүлж доорхи хүснэгтэд үзүүлэв.

Авто машины төрөл	Бодит хөдөлгөөний эрчим маш/хоног	Шилжүүлэлтийн коэффициент	Шилжүүлсэн эрчим маш/хоног
Хөнгөн тэрэг	85	0.43	36,5
Дунд даацын т/х	12	1.0	12
Нийт			48,5

Жилийн хөдөлгөөний өсөлтийг 7% тооцон 20 жилийн хэтийн тооцоот хөдөлгөөний эрчмийг тодорхойлов.

T=20 жилийн дараахи хэтийн хөдөлгөөний эрчим нь:

$$N^{20} = N_n(1 + q)^{(t-1)} = 260,4 * (1 + 0.07)^{19} = 948\text{маш/хоног}$$



Энэхүү шилжүүлсэн эрчмийн ачаалалд тохирох хучилтын шаардагдах эквивалент уян харимхайн модулийг "Авто замын төсөллөлт" /2014он/ номын 16,5-р номограммаас А группын ачаалалд) тодорхойлбол  $E_{\text{обш}}=256\text{МПа}$  байна.

Хучилтын бат бэхийн тооцоо:

Хучилтын хийц сонголт

- Жижиг ширхэгтэй асфальбетон, БНД 90/130 - 0.03м  $E=2400\text{МПа}$
- Том ширхэгтэй асфальтбетон, БНД 90/130 - 0,04м  $E=1800\text{МПа}$   
